



**МОНГОЛ УЛСЫН  
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 26 27 99, Факс: (976-11) 26 27 98,  
Цахим шуудан: info@nird.gov.mn  
Цахим хуудас: www.regional.gov.mn

2024.12.06 № 24/107

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


**Тодруулгад хариу хүргүүлэх  
тухай**

“Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ-аас 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зарласан “Эгийн голын усан цахилгаан станцын төслийн туслах боомтын ТЭЗҮ болон үндсэн ТЭЗҮ-ийн нэмэлт судалгааны ажил (Булган, Хутаг-Өндөр сум) (МУШС/20240103030)”-ын тендер шалгаруулалтын баримт бичигт ирсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	ТББ-ийн ТШЗ 19.2-т заасан нийтийн албан тушаалтанд ямар байгууллагад ажилладаг хүмүүсийг хамааруулах вэ?	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заасан “нийтийн албан тушаалтан”-д Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна.
2	Санал болгож буй мэргэжилтнүүд мэргэжлээрээ мэргэшсэн эксперт бөгөөд нийгмийн даатгалыг улсын зарим байгууллагаас (2, 3 тусдаа байгууллага) давхар төлдөг бол эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийг хавсаргах уу?	Тендерийн баримт бичгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 19.2-т “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заасан нийтийн албан тушаалтныг санал болгох тохиолдолд мөн хуулийн 18.5.3-т заасан удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийг хавсарган ирүүлнэ” гэж тусгасан.
3	Усны эрчим хүчний байгууламж нь усны барилга байгууламжийн нэг төрөл бөгөөд Усны тухай хуулийн 3.1.13 буюу “Усны барилга байгууламж” гэж усны түрэлт,	Усны эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах гэдэгт Усны тухай хуулийн 3.1.13-т заасан “усны барилга байгууламж” буюу усны түрэлт,

<p>урсацыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийг хэлнэ гэж тодорхойлсон. Иймд ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагад "Усны барилга байгууламж"-ийн ажил гүйцэтгэсэн туршлагыг авч үзэх боломжтой эсэх талаар тодруулга өгнө үү.</p>	<p>урсацыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийн чиглэлээр ТЭЗҮ, зураг төсөл боловсруулсан үйлчилгээг авч үзнэ.</p>
--	--

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭРДЭНЭБАЯР